# БАЙГУУЛЛАГЫН НОРМЫН ХУВЦАС, ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ ХУДАЛДАН АВАХ БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ГЭРЭЭ

**Нэг талаас** Чандмань хүүхдийн цэцэрлэгийг төлөөлж Эрхлэгч ажилтай А.Амаржаргал **нөгөө талаас** "Донхорын буянт сүрэг" ХХК-ны захирал Д. Сансарсайхан нар харилцан тохиролцож энэхүү гэрээг 997900 төгрөгний үнийн саналаар байгуулав.

## Нэг: Ерөнхий зүйл

1.1.Монгол Улсын Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу олон нийтийн оролцоотойгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдон захиалагч нийлүүлэгчийн хооронд үүссэн харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
1.2 Гэрээ нь талууд гарын үсэг зурж баталснаар хүчин төгөлдөр болно.

## Хоёр: Захиалагчийн эрх,үүрэг

2.1.Захиалагч нь нийлүүлэгчид захиалах бараа бүтээгдэхүүний нэр, тоо хэмжээг 7 хоногийн өмнө гаргаж өгнө.
2.2. Бараа бүтээгдэхүүний чанар стандарт, тоо хэмжээ зэргийг үзэж нярав хүлээн авч агуулахын бүртгэлд хөтөлж, орлого авна.
2.3. Бүтээгдэхүүний төлбөрийг тухайн сард нь төлж барагдуулах
2.4.Захиалагч нь нийлүүлэгчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хугацаандаа чанартай бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа эсэхэд хяналт тавих

## Гурав: Бэлтгэн нийлүүлэгчийн эрх, үүрэг

3.1.Нийлүүлэгч нь захиалагчийн өгсөн бараа бүтээгдэхүүний нэр, тоо хэмжээний дагуу бараа бүтээгдэхүүнийг тогтоосон цаг хугацаанд нь нийлүүлнэ.
3.2.Захиалагчид бараа бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгөхдөө хүлээлгэн өгсөн зарлагын баримт, нэхэмжлэлийг 2% үйлдэх
3.3. Чанарын шаардлага хангасан, бага насны хүүхдэд тохирсон материал, бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж, үнийг тогтвортой байлгана.
3.4. Захиалагч төлбөрөө хугацаандаа төлөөгүй тохиолдолд төлбөрийг нэхэмжлэх, алданги тооцох

## Дөрөв: Талуудын хүлээх хариуцлага.

4.1. Гэрээнд тусгасан үүргээ биелүүлж, гүйцэтгээгүй тохиолдолд гэм буруутай тал нь нөгөө талдаа тухайн асуудлыг барагдуулж шийдвэрлэнэ.
4.2. Чанаргүй дутуу бараа үйлчилгээг нийлүүлэх, хүлээн авахыг хориглоно.

## Тав: Маргаан шийдвэрлэх

5.1. Талууд хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд харилцан зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулснаар тэрхүү нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

5.2. Энэхүү гэрээгээр үүссэн маргааныг талууд харилцан зөвшилцлийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Эс чадвал маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.
5.3. Гэрээг 3 хувь үйлдэж нийлүүлэгч талд 1 хувийг өгнө.

**Зургаа: Гэрээний үйлчлэх хугацаа.**

**6.1.** Гэрээний үйлчлэх хугацаа: 2019 оны 03 сарын 05-наас 2019 оны 04 сарын 05-ныг хүртэл байна.

**Долоо: БАТАЛГААЖУУЛАЛТ**

| | |
|---|---|
| **ЗАХИАЛАГЧ:** | **НИЙЛҮҮЛЭГЧ:** |
| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
| Цэцэрлэгийн эрхлэгч | "Донхорын буянт сүрэг ХХК-ны захирал |
| ............................ А.Амаржаргал | ............................Д. Сансарсайхан |
| Утас 88263506, 99387105 | Утас |

2019.03.05.

## ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

*[2019.02.25]*

*(Хүүхдийн цэцэрлэгийн)*-ын эрхлэгч А.Амаржаргал танаа

4. Бид *[Донхорын буянт сүрэг хоршоо]* нь дор дурдсан барааг *[997900* төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу *7]* хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
5. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
6. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Нормын хувцас | хос | 3 | 70000 | 210000 | | |
| Ажлын халад | ш | 6 | 40000 | 240000 | | |
| Цоохор даавуу | м | 88 | 4500 | 396000 | | |
| Гарын алчуур | ш | 30 | 3000 | 90000 | | |
| Энгийнцэр | м | 5 | 12380 | 61900 | | |
| дүн | | | | 997900 | | |

Баталгаат хугацаа 6 сар

Донхорын буянт сүрэг хоршооны дарга Д.Сансарсайхан

Дашбямба САНСАРСАЙХАН
Донхорын буянт сүрэг хоршоо
Донхорын буянт сүрэг хоршоо
Дарга